

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/06/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар


**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/33
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх чадварын үнэлгээ буюу Профайлинг үйлчилгээг шинээр нэвтрүүлсэн байна. Уг үйлчилгээнд аймгийн хэмжээнд 431 иргэнийг хамруулан үнэлгээг хийж, А, В үнэлгээ авсан иргэдийг ажилд зуучлах, В,С,Д үнэлгээ авсан иргэдээс өөртэй нь хамтран 11 иргэнийг хувийн төлөвлөгөөг боловсруулан ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Авлага дансны эцсийн үлдэгдэл 2,621,525.0 мянган төгрөг, 1,223,939.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хөтөлбөрүүдийн эргэн төлөгдөх авлага

391,455.5 мянган төгрөг, татаас санхүүжилтийн авлага 832,484.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. Үүнээс хугацаа хэтэрсэн авлага 61,584.8 мянган төгрөг байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	1,397,575,053.00	2,621,515,008.00	
33	АВЛАГА	1,397,575,053.00	2,621,515,008.00	
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	1,397,575,053.00	1,789,030,602.00	
33703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	629,427,451.00	881,155,850.00	
33705	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	116,258,091.00	130,641,191.00	
33706	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	327,293,511.00	401,362,061.00	
33717	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	217,438,000.00	321,322,500.00	
33718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	67,147,000.00	29,945,500.00	
33720	Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс дэмжсэн орон нутгийн онцлогтой төсөл	40,011,000.00	24,603,500.00	
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	832,484,406.00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	-	-	
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	1,397,575,053.00	2,621,515,008.00	
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	-	-	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	1,397,575,053.00	2,621,515,008.00	
51	Засгийн газрын хувь оролцоо	1,397,575,053.00	2,621,515,008.00	
51200	Хуримтлагдсан үр дүн	1,397,575,053.00	2,621,515,008.00	
51210	Өмнөх үеийн үр дүн	1,397,575,053.00	1,397,575,053.00	
51220	Тайлант үеийн үр дүн		1,223,939,955.00	
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	1,397,575,053.00	2,621,515,008.00	

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,914,159,784.00	2,044,855,820.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	164,209,784.00	1,906,925,820.00	
1200	Өмчийн орлого	164,209,784.00	1,906,925,820.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	164,209,784.00	1,906,925,820.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	718,498,600.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	164,209,784.00	359,731,820.00	
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	-	828,695,400.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,749,950,000.00	137,930,000.00	
1310	Улсын төсвөөс	-	137,930,000.00	
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	137,930,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,749,950,000.00	-	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	1,749,950,000.00	-	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,554,374,873.00	820,915,865.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,554,374,873.00	820,915,865.00	
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,415,500.00	33,360,945.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,415,500.00	33,360,945.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,415,500.00	33,360,945.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,549,959,373.00	787,554,920.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	711,001,134.00	-	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	164,209,784.00	-	
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	546,791,350.00	-	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	530,715,089.00	500,522,220.00	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	530,715,089.00	500,522,220.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	308,243,150.00	287,032,700.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	308,243,150.00	287,032,700.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	359,784,911.00	1,223,939,955.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-	
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-	
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	359,784,911.00	1,223,939,955.00	

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,914,159,784.00	2,044,855,820.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	164,209,784.00	1,906,925,820.00
1200	Өмчийн орлого	164,209,784.00	1,906,925,820.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	164,209,784.00	1,906,925,820.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	718,498,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	164,209,784.00	359,731,820.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	-	828,695,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,749,950,000.00	137,930,000.00
1310	Улсын төсвөөс	-	137,930,000.00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	137,930,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,749,950,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	1,749,950,000.00	-
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	530,715,089.00	682,044,451.00
145	Бусад орлого (олз)	530,715,089.00	682,044,451.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	2,444,874,873.00	2,726,900,271.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,444,874,873.00	2,726,900,271.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,495,500.00	33,360,945.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,495,500.00	33,360,945.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,495,500.00	33,360,945.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,440,379,373.00	2,693,539,326.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	711,001,134.00	832,484,406.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	164,209,784.00	832,484,406.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	546,791,350.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	530,715,089.00	500,522,220.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	530,715,089.00	500,522,220.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,198,663,150.00	1,360,532,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,198,663,150.00	1,360,532,700.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=II)	(530,715,089.00)	(682,044,451.00)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	-	-
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	530,715,089.00	682,044,451.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	530,715,089.00	682,044,451.00
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	530,715,089.00	682,044,451.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	НИЙТ ДҮН
1	2022 оны 1-р сарын 1-ний үдэгдэл	-	-	1,037,790,142.00	-	1,037,790,142.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,037,790,142.00	-	1,037,790,142.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	1,037,790,142.00	-	1,037,790,142.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	359,784,911.00	-	359,784,911.00
8	2022 оны 12-р сарын 31-ний үдэгдэл	-	-	1,397,575,053.00	-	1,397,575,053.00
8	2023 оны 1-р сарын 1-ний үдэгдэл	-	-	1,397,575,053.00	-	1,397,575,053.00
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,397,575,053.00	-	1,397,575,053.00
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	-	1,223,939,955.00	-	1,223,939,955.00
16	2023 оны 12-р сарын 31-ний үдэгдэл	-	-	2,621,515,008.00	-	2,621,515,008.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал		ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	
Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-
72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	1,685,124,000.0	1,393,893,645.0
80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	6,700,000.0	6,621,550.0
12	Татварын бус орлого	6,700,000.0	6,700,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	6,700,000.0	6,700,000.0
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого /Үндсэн/	-	6,700,000.0
120010	Төсөвт байгууллагын өөрийн орлого /Туслах/	6,700,000.0	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,700,000.0	6,621,550.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,700,000.0	6,621,550.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,700,000.0	6,621,550.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	6,700,000.0	6,621,550.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,700,000.0	6,621,550.0
82602	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих	186,322,000.0	161,081,500.0
12	Татварын бус орлого	186,322,000.0	249,068,020.0
120	Нийтлэг татварын бус орлого	186,322,000.0	249,068,020.0
120010	Төсөвт байгууллагын өөрийн орлого /Туслах/	186,322,000.0	249,068,020.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	186,322,000.0	161,081,500.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	186,322,000.0	161,081,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	186,322,000.0	161,081,500.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	186,322,000.0	161,081,500.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	186,322,000.0	161,081,500.0
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	137,994,000.0
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	-	137,994,000.0
300001	Харилцах болон хадгаламжийн өөрчлөлт	-	137,994,000.0
82619	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	31,428,000.0	21,756,000.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,428,000.0	21,756,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,428,000.0	21,756,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,428,000.0	21,756,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,428,000.0	21,756,000.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,428,000.0	21,756,000.0
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	31,428,000.0	31,428,000.0
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	31,428,000.0	31,428,000.0
300001	Харилцах болон хадгаламжийн өөрчлөлт	31,428,000.0	31,428,000.0
82620	Хөдөлмөрт бэлтгэх сургалт	57,750,000.0	31,270,000.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	57,750,000.0	31,270,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	57,750,000.0	31,270,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,750,000.0	31,270,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,750,000.0	31,270,000.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,750,000.0	31,270,000.0
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	57,750,000.0
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	-	57,750,000.0
300001	Харилцах болон хадгаламжийн өөрчлөлт	-	57,750,000.0
82621	Аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг	1,132,044,000.0	1,023,165,200.0
12	Татварын бус орлого	1,132,044,000.0	663,470,600.0
120	Нийтлэг татварын бус орлого	1,132,044,000.0	663,470,600.0
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого /Үндсэн/	1,132,044,000.0	663,470,600.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,132,044,000.0	1,023,165,200.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,132,044,000.0	1,023,165,200.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,132,044,000.0	1,023,165,200.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,132,044,000.0	1,023,165,200.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,132,044,000.0	1,023,165,200.0
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,012,687,851.0
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	-	330,643,400.0
300001	Харилцах болон хадгаламжийн өөрчлөлт	-	330,643,400.0
32	ЗГ-ын гадаадын төслийн зээл	-	682,044,451.0
321102	Үндсэн төлбөр (ЗГ-ын дотоод зээл)	-	682,044,451.0
82622	Түр ажлын байрыг дэмжих	217,880,000.0	123,260,000.0
12	Татварын бус орлого	217,880,000.0	-
120	Нийтлэг татварын бус орлого	217,880,000.0	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого /Үндсэн/	217,880,000.0	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	217,880,000.0	123,260,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	217,880,000.0	123,260,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	217,880,000.0	123,260,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	217,880,000.0	123,260,000.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	217,880,000.0	123,260,000.0
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	217,880,000.0
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	-	217,880,000.0
300001	Харилцах болон хадгаламжийн өөрчлөлт	-	217,880,000.0
82623	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардал	53,000,000.0	26,739,395.0
12	Татварын бус орлого	53,000,000.0	-
120	Нийтлэг татварын бус орлого	53,000,000.0	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого /Үндсэн/	53,000,000.0	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	53,000,000.0	26,739,395.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	53,000,000.0	26,739,395.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,739,000.0	26,739,395.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	26,739,000.0	26,739,395.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,739,000.0	26,739,395.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,261,000.0	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,261,000.0	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,261,000.0	-
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	53,000,000.0
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	-	53,000,000.0
300001	Харилцах болон хадгаламжийн өөрчлөлт	-	53,000,000.0
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааг хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэргэжилтэн, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, хөдөлмөрийн зах зээл дэх ажлын байрны шилжилт хөдөлгөөн ажил зуучлал хариуцсан мэргэжилтэн, ажил мэргэжлийн чиг баримжаа хариуцсан мэргэжилтэн нар явуулсан байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлж ажилласан байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилгоор иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх зорилт тавин ажиллажээ.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх чадварын үнэлгээ буюу Профайлинг үйлчилгээг шинээр нэвтрүүлсэн байна. Уг үйлчилгээнд аймгийн хэмжээнд 431 иргэнийг хамруулан үнэлгээг хийж, А, В үнэлгээ авсан иргэдийг ажилд зуучлах, В,С,D үнэлгээ авсан иргэдээс өөртэй нь хамтран 11 иргэнийг хувийн төлөвлөгөөг боловсруулан ажилласан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд аж ахуй эрхлэлтийн сургалтад 29 иргэнийг хамруулснаас 25 иргэнд 168.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, 23 ажлын шинээр бий болгож 92%-тай байна.

Тус газар нь тайлант онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний талаар тусгагдсан 16 зорилт арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн 91.6 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 4, 8, 10, 12, 23, 24, 28, 30 дугаар зүйл,
- Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар бүлэг, 4, 11, 13, 20, 41, 57, 59, 66 дугаар зүйл
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3, 8, 46 дугаар зүйл
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 2,6,2,12,23,29 дүгээр заалтуудад тус тус өөрчлөлт орсон.
- 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдөр Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2022-2023 оны хөтөлбөр"-ийг шинэчлэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн "Дотоод хяналтын нэгж томилох тухай" А/09 тушаалаар шинэчлэн томилж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын 2020 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн А/158 тоот тушаалаар "Дотоод хяналт зохион байгуулалтын журам" боловсруулан баталж мөрдөн ажилласан байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2023 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 01/412 тоот албан бичгийн дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2023 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн А/19 тоот тушаалаар "Эргэн төлөлт 2023" аяныг зохион байгуулах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажилласан байна.

Сумдын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт "Эргэн төлөлт 2023" аяныг зохион явуулах чиглэлийг цахимаар болон албан бичгээр хүргүүлж, зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл, нотлох баримтыг цахимаар авч, сумдаар нэгтгэн байгууллагын хүрээнд дэх facebook messenger групп, дотоод удирдлагын системт байршуулах, эргэн төлөлтийн гэрээнд заасан хугацаа хэтэрсэн 85 иргэнд мэдэгдэх хуудсыг өгч, эргэн төлөлт барагдуулах, өмнөх оны хугацаа хэтэрсэн зээлийг хууль, шүүхийн байгууллагад шилжүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр хугацаа хэтэрсэн зээлийн 106,317.9 мянган төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн №А/289 тоот тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс мөрдөж эхэлсэн байна. Энэхүү баримт бичигт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүртгэл тайлагналын бүртгэлийн үйл ажиллагааг 4 бүлэгт тусгасан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны

заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,223,940.0 мянган төгрөгөөр буюу 87,6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1,397,575.0	2,621,515.0	1,223,940.0
Урьдчилгаа			
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
Нийт хөрөнгө	1,397,575.0	2,621,515.0	1,223,940.0
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,397,575.0	2,621,515.0	1,223,940.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,397,575.0	2,621,515.0	1,223,940.0

Тайлант онд авлага дансны эхний үлдэгдэл 1,397,575.0, мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 2,621,515.0 мянган төгрөг буюу 1,223,940.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь татаас санхүүжилтийн авлага 832,484.0 мянган төгрөгөөр, хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн эргэн төлөгдөх хугацаатай холбоотой авлага 391,456.0 мянган төгрөг байна. Үүнээс хугацаа хэтэрсэн авлага 61,584.8 мянган төгрөг байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,282,411.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 2023 онд хэрэгжих хөдөлмөрт эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний зардлыг 12,778.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, иргэнд олгох санхүүгийн дэмжлэг 260,000.0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох санхүүгийн дэмжлэг 324,509.0 мянган төгрөгөөр бууруулан нийт 1,685,124.0 мянган төгрөгийн төсвийг батлан ирүүлсэн байна. Энэ нь өмнөх оны санхүүгийн дэмжлэгт олгосон гүйцэтгэлтэй холбоотойгоор бууруулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,685,124.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 120,000.0 мянган төгрөгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,685,124.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогоос 359,731.8 мянган төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөөс 682,044.5 мянган төгрөг нийт 2,726,900.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, улсын төсөвт 1,333,006.6 мянган төгрөгийн буцаан төвлөрүүлснээс 832,484.4 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар тусгасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,393,983.6 мянган төгрөг буюу 83,0 хувьтай байгаа нь ажилд зуучлах үйлчилгээ 10,770.0 мянган төгрөг, хөдөлмөрт бэлтгэх сургалт 34,480.0 мянган төгрөг, аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг 100,878.0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 25,240.0 мянган төгрөг, түр ажлын байрыг дэмжих арга хэмжээ 94,620.0 мянган төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаа 25,234.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган

төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Зөвлөл, хороо, комиссын гишүүд 72102-80224	6,700.0	5,413.3	1,286.7	80.8
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих 72102-82602	186,322.0	161,081.5	25,240.5	86.5
3	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ 72102-82619	31,428.0	19,236.0	12,192.0	61.2
4	Хөдөлмөрт бэлтгэх сургалт 72102-82620	57,750.0	23,270.0	34,480.0	40.3
5	Аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг 72102-82621	1,132,044.0	1,028,803.2	103,240.8	90.9
6	Түр ажлын байрыг дэмжих 72102-82622	217,880.0	123,260.0	94,620.0	56.6
7	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардал 72102-82623	53,000.0	32,829.7	20,170.3	61.9
	Дүн	1,685,124.0	1,393,893.7	291,230.3	82.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагад тайлант онд нэмэлт санхүүжилтийн зардал гараагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	72102	2022.01.01 2022.12.31	Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт 91,6%	1,685,124.0	1,393,893.7

			зорилгоор иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх			
--	--	--	---	--	--	--

Тайлант онд хөтөлбөрийн хэрэгжилт 91,6%-тай байгаа нь түр ажлын байруудад ажиллуулах иргэдийн цагийн үнэлгээ доогуур байгаагаас ажиллах хүн олдоогүй, мэргэжил олгох сургалтын жишиг зардал зах зээлийн үнэлгээнээс багаар төсөвлөгдсөнөөс шалтгаалжээ.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага тайлант онд худалдан авалт хийх бараа ажил үйлчилгээ гараагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн хөдөлмөр эрхлэлтийн зээлийн хугацаа хэтэрсэн эргэн төлөлтийн авлагыг бууруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 31 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамнаас баталсан 2023 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамнаас баталсан 2023 оны төсвийг, суурь үзүүлэлтийг 2023 оны батлагдсан төсвийн 1,678,124.0 мянган төгрөгийн нийт зардлаас 1,0 хувиар буюу 16,781.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11,746.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага тайлант онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 100%-тай, 5,0 саяас дээших орлогын 33 гүйлгээ, зарлагын 8 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад тайлант онд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлт, шилэн данстай холбоотой 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын 2023 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 230 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	219,070.9	2	219,070.9	100
Нийт дүн	2	219,070.9	2	219,070.9	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,976,154.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,914,569.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 61,584.8 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 1,914,569.8 мянган төгрөгийн алдаа² илэрснээс аудитын явцад 1,914,569.8 мянган төгрөгийн алдааг залрууллаа.Үүнд:

1.Тус байгууллага тайлант онд санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүнг 285.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2.Тус байгууллага тайлант онд өмнөх оны мөнгөн гүйлгээний тайланг 1,914,159.8 мянган төгрөгөөр зэрэгцүүлэн тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3.Тус байгууллага тайлант онд хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрийн авлага, малчдын хөдөлмөр эрхлэлтийн авлагыг хооронд нь 125.0 мянган төгрөгөөр гүйлгэж зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5.3 Зөвлөмж

Аудитаар нийт 61,584.8 мянган төгрөгийн зөрчил³ илэрснээс, 61,584.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 2019-2023 онуудад хэрэгжиж байгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 хөтөлбөрт олгосон эргэн төлөгдөх зээлээс 29 иргэний 61,584.8 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	
							Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайлант үеийн үр дүнг зөрүүтэй тайлагнасан байна.	1	285.0			1	285.0	1	285.0
Мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оныг 1,914,159.8 мянган төгрөгөөр зэрэгцүүлэн тайлагнаагүй	1	1,914,159.8	1	1,914,159.8			1	1,914,159.8
Хөтөлбөрүүдийн авлагыг хооронд нь гүйлгэж зөрүүтэй тайлагнасан	1	125.0			1	125.0	1	125.0
Дүн	3	1,914,569.8	1	1,914,159.8	2	410.0	3	1,914,569.8

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 2019-2023 онуудад хэрэгжиж байгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 хөтөлбөрт олгосон эргэн төлөгдөх зээлээс 29 иргэний хугацаа хэтэрсэн зээл байна	1	61,584.8					1	61,584.8
Дүн	1	61,584.8					1	61,584.8

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn